



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/194

Сүхбаатар сум

“Мэргэжил сонголт-2019” арга хэмжээг
зохион байгуулах, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдтай аймгийн Засаг даргын хооронд байгуулсан 2019 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний 3.9.4, “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.13, заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчид, багш эцэг эхчүүдэд зориулсан “Мэргэжил сонголт-2019” арга хэмжээг 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Сүхбаатар хотод зохион байгуулсугай.

2. “Мэргэжил сонголт-2019” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. “Мэргэжил сонголт-2019” арга хэмжээнд шаардлагатай 971.460 /есөн зуун далан нэгэн мянга дөрвөн зуун жаран/ төгрөгийг “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардал”-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

4. Зардлын тайланг энэ оны 03 дугаар сарын 25-ны дотор гаргаж танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ